## “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 3 ДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ

2025 оны 09 дүгээр сарын 22 — Багануур дүүрэг

| № | ТЕЗ-ийн үр дүн | Хөтөлбөрийн үр дүн | Бодлогын үндэслэл | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хэрэгжилтийн явц | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | он | түвшин | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО | | | | | | | | | | | |
| 3.2 Үйлдвэрлэл, технологийн парк | | | | | | | | | | | |
| Салбарын үр дүн: Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг 40 хувьд хүргэнэ. | | | | | | | | | | | |
| 230 | Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна. | Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж, үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ. | НХТЖҮЧ-4.3.3 | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Ерөнхий цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих | Ажлын гүйцэтгэл | хувь | 2023 | - | 50 | 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын нийт төсөв 9,911.6 сая төгрөг бөгөөд Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 50% буюу 4,955.8 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 1,048.9 сая төгрөг тусгагдан батлагдаж дараах шатанд ажил явагдаж байна.<br>▪ Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн.<br>▪ Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нээгдэж оролцогч 3 байгууллага шаардлага хангаагүй тул Багануур үйлдвэрлэл технологийн паркийн дэд станцын ажил, 110/35/10кВ-ын НХААГ/20250101634/02/01 урилгын дугаартай тендерийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүртэл дахин зарласан.<br>▪ Гүйцэтгэгчээр Эм Ай Эс Эс ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан.<br>▪ 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр “Эм Ай Эс Эс” ХХК-аас дэд станцын бүтээн байгуулалтын | 60 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ажилтай холбогдуулан газар дээр ирж ажилласан бөгөөд ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлсэн хүлээгдэж байна. | |
| 231 | | | | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг барих | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл | хувь | 2023 | - | 50 | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг барих ажлын хүрээнд:<br><br>▪ Паркийн өмчид Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн хуучин тал барилга байдаг бөгөөд үлдсэн тал барилгыг худалдан авах төсөв 700.0 сая, засвар хийж ашиглалтад оруулах төсөв 2,329.0 сая, нийт 3,029.0 сая төгрөгийн төсөвтэй ажил юм.<br>▪ Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 60% буюу 1,740.0 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 700.0 сая төгрөг тусгагдсан.<br>▪ Нийслэлийн Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад нийслэлийн 2025 оны төсвийн 80 дах заалтад батлагдсан Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилга худалдан авах 700.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр уулзаж 2025.02.06-ны өдрийн 36 дугаар, 2025.02.13-ны өдрийн 42 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн боловч нийслэлийн төсвийн тодотголоор дахин хэлэлцэгдэж хасагдсан тул уг арга хэмжээ 2025 оны 03 сард хэрэгжих боломжгүй болсон.<br><br>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар Паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төслийн 35.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж "Нутаг консалтинг" ХХК нь зураг төслийг гүйцэтгэж 2020 онд хүлээлгэн өгсөн байдаг.<br><br>▪ Тус барилгыг барихад шаардлагатай 2,454.2 сая төгрөгийг Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар саналыг хүргүүлсэн.<br>▪ Мөн 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 135 дугаар албан бичгээр 2019 оны зураг төслийн төсвийг шинэчлэх хүсэлтийг "Нутаг консалтинг" ХХК-д хүргүүлж, онлайн хурал зохион байгуулсан. | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ▪ “Нутаг консалтинг” ХХК-аас 3.0 сая төгрөгөөр төсөв шинэчлэх боломжтой тухай саналыг ирүүлсэн тул төсвийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | |
| | | | | | | | | | Хэрэгжилт | 60% |

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК /хаалттай/
2725850008
8184062 ХНТ9863

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БЯМБАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.МИЧИД-ЭРДЭНЭ

БОДЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ